



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/246

Улаанбаатар хот

Чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.2.1, 2.2.2.3 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Ахлах сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэх талаар баримтлах чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай:

2.1. ахлах сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмжийг 2026 оны 08 дугаар сард багтаан аймаг, нийслэлийн боловсролын газарт хүргүүлэхийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (Х.Отгонбаатар)-д;

2.2. ахлах сургуулийн суралцагчийн суралцах болон ажил мэргэжлийн чиг баримжаа, сонголтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх аргачлал, зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т;

2.3. ахлах сургууль, их сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын хооронд сургалтын үр дүн, багц цаг дүйцүүлэн тооцох, хамтарсан сургалт зохион байгуулахтай холбогдох зохицуулалтын саналыг 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэхийг Дээд боловсролын бодлогын газар (Н.Пүрэвцогт), Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын хэлтэст;

2.4. чадамжид суурилсан мэргэжлийн сургалт болон их сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагаас ахлах сургуультай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулалт, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир), мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын захирал, дээд боловсролын сургалтын байгууллагын ректор, захирал нарт;

2.5. ахлах сургуулийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах лаборатори, дадлагын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, тоног

1426010090

төхөөрөмжөөр үе шаттай хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т;

2.6. ахлах сургуулийн сургалт, үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийн шийдэл бүхий сургалтын платформ, сургуулийн удирдлагын болон суралцахуйн удирдлагын систем, өгөгдөлд суурилсан боловсролын аналитикийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэхийг Цахим боловсролын бодлого, өгөгдлийн шинжилгээний газар (Н.Мөнхсанчир)-т;

2.7.энэ тушаалын хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт.

3. Энэ тушаалын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (В.Түвшинжаргал)-т тус тус даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан “Чиглэл батлах тухай” Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/188 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсролын сайдын 2026 оны 08
дугаар сарын 12-ны өдрийн А/246
дугаар тушаалын хавсралт



АХЛАХ СУРГУУЛИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Суралцагчийн ялгаатай хэрэгцээ, авьяас, сонирхол, цаашид суралцах чиглэл, ажил мэргэжлийн сонголтод суурилсан олон хувилбарт, уян хатан ахлах сургуулийн тогтолцоог хөгжүүлэхэд энэхүү чиглэлийг баримтална.

1.2.Суралцагчийн сонголтод суурилсан суралцах замналыг дэмжих, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, суралцахуйн ахиц, сайн сайхан байдлыг дээшлүүлэх, ирээдүйд шаардлагатай ур чадварыг хөгжүүлэх, дараагийн түвшний боловсролд үргэлжлүүлэн суралцах болон хөдөлмөрийн зах зээлд шилжих бэлтгэл хангах нь ахлах сургуулийн тэргүүлэх чиглэл байна.

1.3. Ахлах сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд суралцагчийн хэрэгцээ, авьяас, сонирхол, ялгаатай байдлыг хүндэтгэх, суралцах замналаа сонгох боломжийг хангах, тэгш хүртээмжийг дэмжих, дижитал шилжилт болон технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, боловсролын түвшин хоорондын залгамж холбоо, хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх зарчмыг баримтална.

Хоёр. Ахлах сургуулийн тогтолцоо, чиг үүрэг, төрөлжилт

2.1.Ахлах сургууль нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.2.4-т заасны дагуу 10-12 дугаар ангитай, бие даасан сургалтын байгууллага байна.

2.2. Ахлах сургууль нь суралцагчдад бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ суралцах, ажил мэргэжлийн замналаа төлөвлөх боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, дараагийн түвшний сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцах болон хөдөлмөрийн зах зээлд шилжихэд шаардлагатай чадамжийг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.Ахлах сургууль нь суралцагчийн хэрэгцээ, авьяас, сонирхол, суралцах хэв маяг, хөгжлийн зорилгод нийцсэн сургалтын хөтөлбөрөөр сонгон судлах болон ахисан түвшний сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлнэ.

2.4. Ахлах сургууль нь сургалтын хөтөлбөрийн онцлогоос хамааран байгалийн шинжлэх ухаан, математик, инженерчлэл, мэдээллийн технологи, эрүүл мэнд, нийгмийн ухаан, хүмүүнлэг, урлаг, дизайн, спорт зэрэг чиглэлээр төрөлжиж болно.

2.5.Төрөлжсөн ахлах сургууль нь дараах хөтөлбөрийг хэрэгжүүлж болно:

2.5.1.их сургууль, коллежтой хамтарсан хөтөлбөр;

2.5.2. олон улсын хөтөлбөр.

2.6. Төрөлжсөн ахлах сургууль нь хүний нөөц, сургалтын орчин, дэд бүтэц, орон нутгийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд үндэслэн энэ чиглэлийн 2.4-т заасан чиглэлээс төрөлжих чиглэлээ тодорхойлно. Төрөлжих чиглэл нь нэг буюу хэд хэдэн чиглэл байж болно.

2.7. Их сургууль, коллежтой хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх ахлах сургууль нь мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагын хүний нөөц, сургалт, судалгааны орчинд түшиглэн шинжлэх ухаан, технологи болон бусад чиглэлээр ахисан түвшний сургалт зохион байгуулж, суралцагчийг дараагийн түвшний боловсрол, сургалтад үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх, судалгаа, инновацын ур чадварыг хөгжүүлэхэд чиглэнэ.

2.8. Олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх ахлах сургууль нь бүрэн дунд боловсролын үндэсний сургалтын хөтөлбөртэй уялдуулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий боловсролын хөтөлбөр (Cambridge, International Baccalaureate (IB) болон түүнтэй адилтгах)-ийг хэрэгжүүлж, суралцагчийг дараагийн түвшний сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцахад бэлтгэнэ.

2.9. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.2.3, 20.3-т заасан бүрэн дунд сургууль, сум дундын сургууль нь үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ мөн хуулийн 20.5-д заасан чиглэлээр холбогдох журамд нийцүүлэн төрөлжсөн сургалт¹ зохион байгуулж болно.

Гурав. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө

3.1. Сургалтын хөтөлбөр нь бүрэн дунд боловсролын заавал судлах агуулга, сонгон судлах хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд суралцагчийн мэдлэг, ур чадварыг бодит нөхцөлд хэрэглэх, асуудал шийдвэрлэх, хувь хүний болон хүн хоорондын чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн бүтээлч үйл ажиллагааг заавал тусгана.

3.2. Сургалтын хөтөлбөр нь суралцагчид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэнэ.

3.3. Сургалтын хөтөлбөр нь суралцагчийн сонголтод суурилан танхимын болон танхимын бус хэлбэрээр хичээл, судалгаа, төсөл, бүтээлч үйл ажиллагаа зохион байгуулах, ажил мэргэжилтэй танилцах дадлага, сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцох боломжийг хангасан байна.

3.4. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө нь анги ахих тусам суралцагчийн сонгон судлах болон бүтээлч үйл ажиллагаанд ногдох сургалтын цагийн хувийг нэмэгдүүлэх зарчимд үндэслэнэ.

3.5. Сонгон судлах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, их сургууль, коллежтой хамтран хэрэгжүүлэх хөтөлбөрийг тусгана.

3.6. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, их сургууль, коллеж нь хэрэгжүүлэх хамтарсан хөтөлбөрөө төрөлжсөн ахлах сургуульд санал болгох бөгөөд тухайн хөтөлбөрт боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага дүгнэлт гаргана. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тухайн хөтөлбөрийг санал болгосон байгууллага мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

3.7. Төрөлжсөн ахлах сургууль нь чадамжид чиглэсэн мэргэжлийн сургалт зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд суралцагчийн эзэмшсэн чадамжийг холбогдох байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоотой хамтран үнэлж, хууль тогтоомжид заасан журмын дагуу баталгаажуулна.

¹ Энэ чиглэлийн 2.9-д заасан "төрөлжсөн сургалт" гэдэгт суралцагчийн авьяас, чадвар, сонирхлыг хөгжүүлэх зорилгоор дунд ангиас эхлэн тодорхой чиглэлээр тухайн түвшний боловсролын агуулгыг өргөжүүлэн, гүнзгийрүүлэн судлуулахаар зарим анги, бүлэгт зохион байгуулах сургалтыг хамааруулна.

**Дөрөв. Суралцах замнал, боловсролын түвшин
хоорондын залгамж холбоо, хамтын ажиллагаа**

4.1. Суралцагч нь ахлах сургуулийн хөтөлбөр хооронд шилжин суралцах боломжтой байна.

4.2. Төрөлжсөн ахлах сургууль нь суралцагчийн суралцах болон ажил мэргэжлийн замналыг дэмжих зорилгоор сургалт, судалгаа, төсөл, дадлага, ажил мэргэжилтэй танилцах болон бусад үйл ажиллагааг мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, их сургууль, коллеж, мэргэжлийн холбоо, ажил олгогч болон бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

4.3. Төрөлжсөн ахлах сургуулийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, чадамж, сургалтын үр дүнг мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, их сургууль, коллежийн сургалтын хөтөлбөртэй уялдуулан холбогдох журмын дагуу үнэлж, дүйцүүлэн тооцож болно.

4.4. Төрөлжсөн ахлах сургууль нь суралцагчийг дараагийн түвшний сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх зорилгоор мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, их сургууль, коллеж, ажил олгогчтой хамтран ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйл ажиллагаа зохион байгуулна.

Тав. Төрөлжсөн ахлах сургуулийн үйл ажиллагааны зохион байгуулалт

5.1. Сургууль нь нэг ээлжтэй, бүтэн өдрийн сургалтын зохион байгуулалттай байна.

5.2. Сургууль нь суралцагчид сургалтын хөтөлбөрийн сонголт, суралцах болон ажил мэргэжлийн замналын төлөвлөлтийг дэмжих, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий суралцагчийн асуудал хариуцсан нэгжтэй байна.

5.3. Сургууль нь суралцагчийн суралцахуйн ахиц, үр дүн, сайн сайхан байдал, ажил мэргэжлийн төлөвлөлтийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, чанарыг баталгаажуулах дотоод зохион байгуулалттай байна.

5.4. Сургууль нь хамран сургах тойргоос үл хамааран суралцагч элсүүлж болно. Элсэлт нь нээлттэй, ил тод, шударга, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зарчимд үндэслэнэ.

5.5. Сургууль нь суралцагчийн суралцах замнал, ажил мэргэжлийн сонголтыг дэмжих зорилгоор Боловсролын ерөнхий хуулийн 12.2-т заасан багш мэргэжлийн сонгон бүлгийг холбогдох журамд нийцүүлэн хичээллүүлж болно.

5.6. Суралцагч бүр суралцах болон ажил мэргэжлийн хөгжлийн хувь хүний төлөвлөгөө боловсруулж, ахлах сургуулийн суралцах хугацаанд хэрэгжүүлнэ.